



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭЭДЭЭ

№244 /453/

2022.01.11

Цаг үе, үйл явдал

ЭРДЭМТЭН МЭРГЭДҮҮД ЧУУЛЛАА



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-23

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.470	3.475
EUR	3.715	3.740
CNY	510.50	513
RUB	48	48.80
JPY	26.30	26.60
KRW	2.83	2.86

ЗУРХАЙ



2022.01.11 / ЛХАГВА ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 19

**ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА
САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ
ШАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:
Сайн нөхөртэй нөхөрлөнө
Наран ургах, шингэх:
08.39-17.20
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Хурьцахуй

Батлан хамгаалахын удирдлагын академийн 30 жилийн түүх, академийн хөгжлийн стратегийг тодорхойлох зорилгоор "Батлан хамгаалахын удирдлагын академи-30 жил: Өнөө ба ирээдүйн хөгжлийн чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна.

Эл хуралд ҮАБЗ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, ХХЕГ, ОБЕГ-ын удирдлага, ҮБХИС, БХУА-ийн үе үеийн болон одоо ажиллаж буй удирдлагууд, төгсөгчид, сонсогчдын төлөөлөл оролцлоо.

Хурлыг нээж ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан хэлсэн үгэндээ "Монгол Улсын Зэвсэгт хүчин мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг боловсон хүчинтэй болох тэргүүн зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна. Анх Батлан хамгаалахын сайдын 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн тушаалаар ҮБХИС цэргийн дээд боловсролтой боловсон хүчнийг дотооддоо

бэлтгэх хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн БХУА-ийг "Оперативын факультет" нэртэйгээр үүсгэн байгуулж байв. Өдгөө уг академийн 30 жилийн ойн босгон дээр ирээдүйн бодлого, зорилтоо тодотгохоор бид бүхэн хуран цугласан нь дээрх шийдвэр алсын хараатай оновчтой, зөв зүйтэй зүйл байсныг батлан харуулж байна" гэлээ.

Хурлын хүрээнд БХУА-ийн захирал, докторант, бригадын генерал Л.Онцгойбаяр "БХУА-ийн өнөө ба ирээдүйн хөгжлийн чиг хандлага", Монгол Улсын гавьяат багш, доктор (Ph.D) профессор ҮБХИС-ийн Хүндэт доктор Б.Түмэн "БХУА-ийн Батлан хамгаалах салбарт оруулж буй хувь нэмэр", ҮАБЗ-ийн ажлын албаны стратегийн бодлогын хэлтсийн дарга, доктор (Ph.D) хурандаа Р.Энхболд "Үндэсний аюулгүй байдлын судлагдахуун, онцлох асуудлууд", БХЭШХ-ийн захирал, доктор (Ph.D) хурандаа Б.Эрдэнэбат "Хөгжингүй орнуудын удирдах

бүрэлдэхүүнийг бэлтгэж буй туршлага, сургамж", Хилийн цэргийн ЭШХ-ийн дэд захирал, доктор (Ph.D) хурандаа Ц.Одбаяр "Улсын хил хамгаалалт ба удирдах бүрэлдэхүүнийг бэлтгэж буй туршлага, цаашдын чиг хандлага" сэдвээр тус тус илтгэл тавьж нийт бие бүрэлдэхүүний дунд нэгдсэн хэлэлцүүлгийг өрнүүлсэн юм.

Тус академи нь Удирдлага, Эрдэм шинжилгээ сургалтын алба, Аюулгүй байдал стратегийн төв, Операц-тактикийн төв, Цэргийн удирдлагын төвийн эрдэмтэн багш, судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр "Операц-тактик цэргийн удирдлага"-ын мэргэжлээр магистрын зэрэг олгох албан тушаалын болон ахисан түвшний сургалтыг зохион байгуулж, улсыг батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах бодлогын чиг үүргийг хэрэгжүүлэх чадавхтай удирдах албан тушаалтныг Монгол Улсын Батлан хамгаалах салбар болон төрийн цэргийн байгууллагуудад бэлтгэн гаргасаар байна.



БНТУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН АТТАШЕГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Батлан хамгаалахын атташе хурандаа Өзгүр Назым Унсалын хүсэлтийг хүлээн авч уулзав.

Уг уулзалтаар хоёр орны цэргийн хамтын ажиллагааны талаар санал солилцсоны зэрэгцээ хурандаа Өзгүр Назым Унсал энэ жил зохион байгуулагдах "Хаан эрэлд" олон улсын энхийг сахиулах ажиллагааны сургуульд Бүгд Найрамдах Турк Улсаас салаа хүртэлх бие бүрэлдэхүүн оролцуулахаа мэдэгдсэн юм.

Хошууч Ц.ПҮРЭВДОРЖ



**КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 669,383,343

Эдгэрсэн

Нийт: 640,893,119

Нас барсан

Нийт: 6,717,896

Цахим шууданд

УУЛЗАЛТААР ОЛОН АРГА ХЭМЖЭЭГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТОГТЛОО



Төв аймгийн удирдлага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дарга нарын уулзалт, ярилцлага энэ сарын 10-ны Хуурай замын цэргийн командлалд зохион байгуулагдлаа. Энэ нь аймгийн удирдлага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог дээшлүүлэх, 2023 онд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нэгдсэн ойлголтод хүрэхэд чиглэжээ.

Уулзалтад аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар тэргүүтэй албаныхан, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал, штабын дарга, хурандаа Ц.Буяндэлгэр, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Төмөрчөдөр нарын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага оролцсон юм. Уулзалтаар хэд хэдэн асуудал хөндөн ярилцсаны

дотор 2023 онд Төв аймгийн түүхт 100 жилийн ой тохиож буйтай холбогдуулсан арга хэмжээнд оролцох, алдар суутай зарим жанжны хөшөөг сэргээн засварлах зэрэг цаг үеийн шаардлагуудыг аймгийн зүгээс онцлон дурдав.

Мөн энэ үеэр бригадын генерал Ч.Цогтжаргал Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын алба хаагчдын нийгмийн асуудалд орон нутаг дэмжлэг үзүүлж ажиллахыг хүсээд маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай мэдээлэл хүргэсэн юм.

Талууд түүхт ой угтсан арга хэмжээнээс гадна алба хаагчдынхаа хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, орон нутагтаа иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, ахмад дайчдаа алдаршуулах, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэхэд хамтарч, олон арга хэмжээг хэрэгжүүлэхээр тогтлоо.

Ахмад Д.БОЛОР, Гэрэл зургийг О.МӨНХБАТ



ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОХЫГ УРИАЛЖ БАЙНА

Монгол цэргийн нэгдсэн холбоо болон "Отгонтэнгэр" их сургууль хамтран Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагад цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хааж буй түрүүч, байлдагч нарын дунд "Миний хааж буй цэргийн алба" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зарлажээ. Энэхүү уралдааны зааврыг сайтар судлан цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдаа өргөнөөр оролцуулахыг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч, удирдлага, соёл хүмүүжлийн ажилтнуудад уриалж байна.

Уралдааны шагналын сан өндөр зарлагдсан бөгөөд хамгийн чухал нь манай улсын их, дээд сургуулиудын тэргүүн эгнээнд нэрлэгддэг "Отгонтэнгэр" их сургуульд эхний нэг жилийн хугацаанд сургалтын төлбөрөө 50-100 хувь хөнгөлүүлэх эрхийн бичгээр 13 цэргийн алба хаагч шагнагдах болсон нь илт давуу тал гэдэг нь мэдрэгдлээ. Та бүхэнд амжилт хүсье.

ЗХЖШ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЛБА

"МИНИЙ ХААЖ БУЙ ЦЭРГИЙН АЛБА" СЭДЭВТ ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

- Нэг. Уралдааны зорилго, зорилт**
Зорилго: Хугацаат цэргийн алба хаагчдад эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлын дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх үзэл хүмүүжил олгох, тэдэнд эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх, мэдлэгээрээ баялаг бүтээж, манлайлах чадвартай, ёс суртахуунтай мэргэжилтнийг эх орондоо бэлтгэх.
- Зорилтууд:**
 - Хугацаат цэргийн алба хаагчдын эх оронч үзэл, сэтгэлгээг өдөөн дуудах;
 - тэдний сэтгэн бодож, найруулан бичих үр чадварыг дээшлүүлэх,
 - дайчдын өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэх.
- Хоёр. Хамрах хүрээ**
 Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын харьяа анги, байгууллагад цэргийн жинхэнэ алба хааж буй хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчид оролцох боломжтой.
- Гурав. Зохион байгуулалт**
 Монгол цэргийн нэгдсэн холбоо, Отгонтэнгэр их сургууль, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, түүний харьяа цэргийн анги, байгууллагууд.
- Дөрөв. Эсээ бичлэгт тавигдах шаардлага**
 Эсээний сэдэв нь "Миний хааж буй цэргийн алба" гэсэн гол сэдвийн агуулгад нийцсэн байна. Дайчид эсээний сэдвийг захирагч, дарга нартайгаа зөвлөлдөн сонгож болно. Эсээний эхэнд бичигчийн товч танилцуулга (үгийн тоонд орохгүй)-ыг оруулсан байна.
- Эсээд дараах асуултад хариулахыг хичээгээрэй**
 - Цэргийн алба амьдралд тулгарч буй асуудлыг давах суурь болж байна уу?
 - Цэргийн алба хааж явцдаа өөрийнхөө ямар ямар хүчтэй, сул талуудаа танин мэдэв
 - Цэргийн алба хааж эх орныхоо үнэнч шударга иргэн болохыг харуулна.
 - Монгол эх орон миний тэргүүлэх үнэт зүйл
 - Би цаашдаа... мэргэжил эзэмшиж иргэнийхээ ажил, амьдралын гарааг эхлэх эрмэлзлэлтэй болж байна.
- Эсээ дараах шаардлагыг хангасан байна:**
 - Эсээ бичлэгийн хэл найруулга, бичлэгт тавигдах ерөнхий шаардлагыг хангасан байх;
 - Чөлөөт сэтгэлгээ, бичлэгийн үр чадварыг эзэмшсэн, дүр дүрсэл сайтай байх;
 - Шинэлэг санааг давшуулсан байх;
 - Ашигласан эх сурвалжийг тодорхой дурдсан байх;
 - 1000 үгэнд багтаасан байх;

- Тав. Эсээг хүлээн авах, шалгаруулах журам**
 Эсээг бичлэгийн уралдааныг хоёр үе шаттай явуулна.
- Нэгдүгээр шатанд** Зэвсэгт хүчний жанжин штаб 2023 оны 01 дүгээр сарын 10-наас 2023 оны 01 дүгээр сарын 30-ны хооронд цэргийн анги, байгууллагуудад зохион байгуулж, уралдаанд ирсэн эсээнүүдийг нэгтгэн Монгол цэргийн нэгдсэн холбоонд ирүүлнэ.
- Хоёрдугаар шатанд** Монгол цэргийн нэгдсэн холбоонд ирсэн эсээг 0-100 хүртэл онооны системээр дүгнэж, нийлбэр дүнгээр байр эзлүүлнэ. Шалгаруулахад баримтлах шалгуур үзүүлэлтүүд:
 - Найруулга, зөв бичих дүрмийн шаардлага, үгийн тоо (15 оноо);
 - Бичих үр чадвар (20 оноо);
 - Хөндсөн санаа, агуулын шинэлэг байдал (15 оноо);
 - Давуулсан санааны үндэслэл (30 оноо);
 - Сэдэв, зорилго, агуулга, дүгнэлтийн уялдаа холбоо (20 оноо).
- Оролцогч өөрийн товч танилцуулга, анги, байгууллагын нэр, дугаарыг тодорхой бичиж хавсаргана.
- Эсээг сэдвийн хүрээнд бичиж, ашигласан эх сурвалжийг тодорхой дурдсан байх бөгөөд шууд хуулбарласан, хугацаа хожимдсон, шаардлага хангаагүй материалыг шалгаруулахад оролцуулахгүй.
- Шалгаруулахад ирүүлсэн эсээг хэвлэл мэдээлэлээр сурталчилж, эмхтгэл болгон хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгоно.
- Зургаа. Шагналыг урамшуулал**
 - Нэгдүгээр байр нэг, Талархлын бичиг, 400.000 төгрөг;
 - Хоёрдугаар байр нэг, Талархлын бичиг, 200.000 төгрөг;
 - Гуравдугаар байр нэг, Талархлын бичиг, 100.000 төгрөг;
 - Эсээ бичлэгийн тэргүүн байр эзэлсэн оролцогчийг эхний жил 100 хувийн сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй Отгонтэнгэр их сургуульд суралцах эрх (Оксфордын их сургуулийн EAP англи хэлний хичээлийн сурах бичгийн бичгийн төлбөр үүнд хамаарахгүй);
 - Эсээ бичлэгийн дэд болон гутгаар байр эзэлсэн оролцогчийг эхний жил 70 хувийн сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй Отгонтэнгэр их сургуульд суралцах эрх (Оксфордын их сургуулийн EAP англи хэлний хичээлийн сурах бичгийн бичгийн төлбөр үүнд хамаарахгүй);
 - Эхний 10 оролцогчийг Отгонтэнгэр их сургуулийн бүх мэргэжлийн ангид эхний жил 50 хувийн сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй (Оксфордын их сургуулийн EAP англи хэлний хичээлийн сурах бичгийн төлбөр үүнд хамаарахгүй) суралцах эрхээр;
 - Өөрийн анги, байгууллагын хугацаат цэргийн алба хаагчдын эсээ бичлэгийн уралдаанд өргөнөөр хамруулсан Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын харьяа анги, байгууллагын байнгын бие бүрэлдэхүүн болон ар гэрийн төлөөллийг (нийт 3 хүнийг) Отгонтэнгэр их сургуулийн магистрантур, докторантурт 30 хувийн сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцах эрхээр шагнаж урамшуулна.

Цахим шууданд

"ХАРИУЦЛАГАТАЙ ЖОЛООЧ-ХАР ХАЙРЦАГ" ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ



Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас төрийн болон төрийн бус байгууллагын жолооч, хувиараа тээврийн үйлчилгээ үзүүлдэг таксины жолооч нарын дунд "ХАРИУЦЛАГАТАЙ ЖОЛООЧ-ХАР ХАЙРЦАГ" зөвлөгөөнийг энэ оны 01 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулж, аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Баатархүү, Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Алтансүх, Авто тээврийн төвийн дарга Э.Ниндэв нар оролцож, сургалт зохион байгуулан, жолооч нарын санал хүсэлтийг нь сонсож, мэдээ, мэдээлэл солилцов.

Зөвлөгөөнд оролцсон жолооч нар аймгийн Засаг даргын орлогч Г.Мөнхзаяагаас гаргасан "Хариуцлагатай жолооч-хар хайрцагтай" уриалгыг дэмжиж, автомашины хар хайрцгийг ашиглаж эхлэхээр шийдвэр гарган, бусад жолооч нарт зөвлөгөөний мэдээллийг хүргэхээ илэрхийллээ.

ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБА

Сэрэмжлүүлэг



ИРГЭД, ЖОЛООЧ НАРЫН АНХААРАЛД

2023.01.11-нээс баруун аймгуудын нутгийн зарим газар, төвийн аймгуудын нутгийн хойд хэсгээр, 12-нд ихэнх нутгаар, 13-нд говь болон зүүн аймгуудын нутгаар цас орж, цасан шуурга шуурч, 12-ноос ихэнх нутгаар хүйтний эрч эрс чангарч, 11-13-нд Алтайн салбар уулс болон говь, тал, хээрийн нутгаар хүчтэй салхи, шороон шуургатай байхыг Ус цаг уур орчны шинжилгээний газраас анхааруулсан байна.

Иймд орон нутагт зорчиж буй иргэд, жолооч та бүхэн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, дулаан хувцас, шатах тослох материалыг нөөцөлж өөрийн болон бусдын аюулгүй байдлыг ханган хөдөлгөөнд оролцохыг анхааруулж байна.

ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБА